



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 195

Улаанбаатар хот

“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн зохион байгуулалтын бүтцийн схем, орон тооны дээд хязгаарыг өөрчлөн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дах заалт, “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 6.8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн зохион байгуулалтын бүтцийн схемийг хавсралтаар өөрчлөн баталсугай.

2.“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн орон тооны дээд хязгаарыг 950 (есөн зуун тавь) байхаар тогтоосугай.

3.Шинээр батлагдсан ажлын байрны тодорхойлолтыг баталж, цалингийн эх үүсвэрийг батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэхийг “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал (О.Батчулуун)-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн зохион байгуулалтын бүтцийн схем, албан тушаалын жагсаалт шинэчлэн батлах тухай” 379 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалттын газрын  
2025 оны 04 дугаар сарын 22-ны өдрийн  
дугаар тогтоолын хавсралт

